

## НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Аудит хийгдэх байгууллага: “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын 2015, 2016 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх

2017 он

## АГУУЛГА

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ .....	3
1. ТАНИЛЦУУЛГА .....	4
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ .....	5
2.1. АУДИТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....	5
3. АУДИТЫН ҮР ДҮН .....	6
3.1. Илэрсэн асуудлууд .....	6
<i>Зорилт 3.1.1. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх болон “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж байгаа байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх; .....</i>	6
<i>Зорилт 3.1.2. Хөтөлбөрийн Ногоон тэжээл үйлдвэрлэлд бэлчээрийн шинэ менежмент, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, Малчид фермерүүдийн хоршоодыг байгуулах, Хөтөлбөр хэрэгжих газарт загвар аж ахуй болон сургалтын төвийг цогцоор байгуулж ажиллуулах, Техник дундын үйлчилгээний төвийг бий болгоход холбогдох байгууллагуудын оролцооны байдалд дүгнэлт өгөх; .....</i>	9
<i>Зорилт 3.1.3. Хөтөлбөрийн үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-аас зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүн, тайлагналтад үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгөх; .....</i>	11
<i>Зорилт 3.1.5. Байгууллагын төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгөх; .....</i>	14
3.2 ДҮГНЭЛТ .....	17
3.3. ЗӨВЛӨМЖ .....	17

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НДАА	Нийслэлийн Дотоод аудитын алба
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НИТХТ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НЗД	Нийслэлийн Засаг дарга
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НҮХААГ	Нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
НББ	Нягтлан бодох бүртгэл

## ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

Нийслэлийн Дотоод аудитын хорооны дарга С.Батболдын баталсан Нийслэлийн Дотоод аудитын албаны 2017 оны аудитын жилийн төлөвлөгөөний дагуу “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын 2015, 2016 оны үйл ажиллагаанд 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд аудитыг хийж гүйцэтгэлээ.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ хийгдсэн 2015, 2016 оны гүйцэтгэлийн аудитаар тус байгууллагын үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд явагдаж байгаа тул “Сайжруулалт хэрэгтэй” үнэлгээ, 12 зөвлөмжийг аудитын багаас өгч байна.

### **Дотоод аудитаар илэрсэн гол асуудлууд:**

**Нэг. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх болон “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж байгаа байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх зорилтын хүрээнд;**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тухайн жилд төлөвлөсөн ажлуудын өөрийн байгууллагаас шалтгаалах ажлуудаа бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

**Хоёр. Хөтөлбөрийн Ногоон тэжээл үйлдвэрлэлд бэлчээрийн шинэ менежмент, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, Малчид фермерүүдийн хоршоодыг байгуулах, хөтөлбөр хэрэгжих газарт загвар аж ахуй болон сургалтын төвийг цогцоор байгуулж ажиллуулах, Техник дундын үйлчилгээний төвийг бий болгоход холбогдох байгууллагуудын оролцооны байдалд дүгнэлт өгөх зорилтын хүрээнд;**

Дэвшилтэд технологиор тариалалт хийж эхлүүлсэн ба загвар аж ахуй, сургалтын төвийг цогцоор байгуулсан байна. Харин малчид, фермерүүдийн хоршоодыг байгуулах, техник дундын үйлчилгээний төвтэй болох ажил 2017 оноос хэрэгжинэ.

**Гурав. Хөтөлбөрийн үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-аас зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүн,**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тухайн жилд төлөвлөсөн ажлуудын өөрийн байгууллагаас шалтгаалах ажлуудаа бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Малчид, фермерүүдийн хоршоо байгуулж 90 үхрийн цогцолборт саалийн болон өсвөр насны үхэртэй болох асуудал шийдвэрлэгдээгүй нь малчид, фермерүүд суурьшсан нутгаасаа шилжиж нүүх сонирхол байхгүйтэй холбоотой байна.

**Дөрөв. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр өгөөж, үр ашигтай байдал, худалдан авах ажиллагаа, холбогдох гэрээ хэлцлийн хэрэгжилтэд үнэлэлт, зөвлөмж өгөх зорилтын хүрээнд;**

Нийслэлийн Дотоод аудитын хорооны даргын баталсан удирдамжийн дагуу хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээнд тус албанаас аудит хийж байгаа тул энэ зорилтыг хязгаарласан болно.

**Тав. Төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх зорилтын хүрээнд;**

Аудитанд хамрагдах хугацаанд төсвийн захирагч батлагдсан төсвөө зориулалтын дагуу хэрхэн үр ашигтай зарцуулсан, өөрийн орлогын бүрдүүлэлт зарцуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, санхүү бүртгэл хөтлөлтийн байдлыг үзэж үнэлэлт дүгнэлт, заавар, зөвлөгөө өгөхөд голчлон анхаарч ажилласан болно.

## 1. ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл 2014 оны 09 дүгээр сард Бүгд Найрамдах Австри улсад айлчлахдаа Улаанбаатар хотын тулгамдсан асуудал болох цөлжилтийг бууруулах чиглэлээр "Раумберг-Гумпенштайн" Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хөдөө аж ахуйн сургалт, судалгааны төвийн эрдэмтэн, доктор К.Бухграбер ахлагчтай багийн боловсруулсан төслүүдтэй танилцаад "Нийслэл орчмын бэлчээрийг сайжруулах, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-ийг хамтран боловсруулах, улмаар хөтөлбөр болгон хэрэгжүүлэхээр тохиролцсон байна.

НИТХТ-дийн 2015 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, нийслэлийн нутаг дэвсгэр дээр хөдөө аж ахуйн тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ыг НИТХТ-дийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор байгуулж, дүрмийг баталсан байна.

Төслийн нэгжийн үндсэн зорилгыг "Батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлж, Австри улсын дэвшилтэд технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, малчид, фермерүүдийн идэвх оролцоонд тулгуурлан бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулахад оршино" гэж тодорхойлжээ.

Хөтөлбөр нь нийтлэг үндэслэл, зорилго, зорилт, хэрэгжүүлэх үе шат, хэрэгжих байршил, хамтран хэрэгжүүлэх түнш, хөтөлбөрийн тооцоо, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн, хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт, удирдлага, зохион байгуулалт, шалгуур үзүүлэлт, тайлагналт, хяналт-шинжилгээ гэсэн 11 бүлэгтэйгээр боловсруулагдан батлагдсан байна.

Хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын ажлууд 2015, 2016 онуудад ерөнхийдөө хийгдсэн учир цаашид гадаад мэргэжилтэн урьж ажиллуулах, зөвлөх үйлчилгээ авах, үр бордоогоор хангуулах болон ажиллагсдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг үйл ажиллагааны урсгал зардлаар санхүүжигдэн ажиллахаар төлөвлөгдсөн байна.

Уг хөтөлбөр 2020 он хүртэл хэрэгжсэнээр хот орчмын бүсэд мал аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлэхэд хөрс цаг уурын нөхцөлд тохирсон, ургах чадвар өндөр, ногоон масс ихтэй тэжээлийн ургамлыг нутагшуулж, малчид, фермерүүдийн идэвх оролцоонд тулгуурлан бэлчээрийн менежмент шинэчлэгдэнэ.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

### 2.1. АУДИТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн тухайн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд хяналт шалгалт хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, засаглал ба дотоод хяналтын үйл явцыг үнэлэх, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхээр хараат бус үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Аудитын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

1. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх болон “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж байгаа байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх;
2. Хөтөлбөрийн Ногоон тэжээл үйлдвэрлэлд бэлчээрийн шинэ менежмент, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, Малчид фермерүүдийн хоршоодыг байгуулах, Хөтөлбөр хэрэгжих газарт загвар аж ахуй болон сургалтын төвийг цогцоор байгуулж ажиллуулах, Техник дундын үйлчилгээний төвийг бий болгоход холбогдох байгууллагуудын оролцооны байдалд дүгнэлт өгөх;
3. Хөтөлбөрийн үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-аас зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүн, тайлагналтад үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгөх;
4. Төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгөх;

### 2.2. АУДИТЫН ЦАР ХҮРЭЭ

Дотоод аудитыг олон улсын стандартыг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнуудаас лавлагаа тодруулга авах, удирдамж стандартад заасны дагуу дүгнэлт, зөвлөмжинд дэмжлэг болох нотлох баримт, мэдээ мэдээлэл, судалгааг гаргуулан гүйцэтгэв. Тухайлбал:

- ❖ Байгууллагын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох журам, тушаал, гэрээ, хэлцлүүд;
- ❖ Дээд газартай байгуулсан Үр дүнгийн гэрээ;
- ❖ Байгууллагын стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтүүд;
- ❖ Үйл ажиллагааны 2015, 2016 оны төлөвлөгөө, тайлан;
- ❖ Байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтууд;
- ❖ Байгууллагын даргын 2016 онд гаргасан тушаал, шийдвэрүүд;
- ❖ 2016 оны материалын болон шатахууны тайлан;
- ❖ Байгууллагын 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хавсралт материалууд зэргийг хамруулав.

### 3. АУДИТЫН ҮР ДҮН

#### 3.1. ИЛЭРСЭН АСУУДЛУУД

**Зорилт 3.1.1.** Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх болон “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж байгаа байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх;

#### Шалгуур:

- НИТХ-ын баталсан НЗД-ын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Нийслэлийн 2015, 2016 оны эдийн засаг, нийгмийн зорилт;
- "Нийслэлийн 2015 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" НИТХ-ын 2015 оны 24/04 дүгээр тогтоол;
- НИТХТ-дийн 2015 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр";
- НИТХТ-дийн "Нийслэлийн тусгай хамгаалалтанд авах тухай" 2015 оны 73 дугаар тогтоол;
- СХД-ийн ИТХТ-дийн "Орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай" 2015 оны А/79 дүгээр тогтоол;

#### Бодит нөхцөл байдал:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.1, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор хөтөлбөрт зориулан 2015, 2016 онуудад нийт 2063.2 сая төгрөг зарцуулан 90 үнээний зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермерийн аж ахуйн барилга байгууламжуудыг барих, гүний худгууд гаргах, цахилгаан хангамжтай болгох, тэжээлийн талбайг хаших, авто зам, фермерийн дотоод тохижилт хийх, хадлан, тэжээлийн техник, тоног төхөөрөмжүүдийг худалдан авах зэрэг ажлуудыг нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /тухайн үеийн нэрээр/ удирдан зохион байгуулж зураг төсөв, гэрээний дагуу хийж гүйцэтгүүлсэн байна.

Гүний худаг



Сургалтын төв, үнээний байр



Техник дундын үйлчилгээний төв



Тэжээл хадгалах саравч



Анжист трактор



Эрдэс бордоо цацагч



Вакумжуулан боогч



Хөргөлтийн систем бүхий автомат саалтуур





Энэхүү хөтөлбөрийг Засгийн газрын болон НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх" заалтуудын зорилгод тулгуурлан үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх түнш байгууллагаар нийслэлийн болон төсөл хэрэгжих дүүргүүдийн ЗДТГ, НҮХААГ, Байгаль орчин, ногоон хөгжлийн газар /тухайн үеийн нэрээр/, иргэд, аж ахуйн нэгжүүд байхаар баталжээ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд байгууллагуудын оролцоог авч үзвэл:

- Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар /тухайн үеийн нэрээр/, Зураг төслийн хүрээлэн барилга байгууламжуудын зураг төсөл боловсруулахад чиг үүргийн дагуу оролцсон;
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар зардлын тооцоо гаргах, тендер зарлахад холбогдох материалуудыг гаргаж өгсөн;
- СХД-ийн ИТХТ-чид "Орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай" 2015 оны А/79 дүгээр тогтоол гаргасанд үндэслэн дүүргийн Өмч, газрын харилцааны алба /тухайн үеийн нэрээр/ 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Нарийний хөндийн " Шар хоолойн ам"-анд төлөвлөгдсөн 1800 га газраас өнөөдрийн байдлаар 500 га газрыг олгож газрын нэгдсэн мэдээллийн санд оруулан баталгаажуулсан;
- НИТХТ-дийн 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 73 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх "Улиастайн голын эх"-ийн 22818,1 га газрыг нийслэлийн тусгай хамгаалалтанд авч байгалийн цогцолборт газар болгосны 7500 га газрыг тухайн үеийн нэрээр нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт эзэмшүүлж уг төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн;
- Нийслэлийн Өмчийн харилцааны газар хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг данс бүртгэлд авах тухай төслийн нэгжээс тавьсан хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн ажиллажээ.

Хөтөлбөрийн 9.1-д "... хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, түүний үр дүнг жил бүр тооцоо ажлыг НҮХААГ хариуцаж удирдлага арга зүйгээр ханган ажиллах"-аар заасан байна.

Хөтөлбөрт заасны дагуу НҮХААГ хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн тайланг гаргасанд үндэслэн нийслэлийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс үнэлгээ өгч НИТХ-ын Ажлын албанд тайлангийн хамт хүргүүлэн ажиллажээ. /Хэрэгжилтийн явцыг нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй/

#### **Шалтгаан:**

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад томоохон хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан ажиллах шаардлага гарсан учир НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг НҮХААГ-ын чиг үүргийг тусгаарлан "Бэлчээрийн менежментийн төслийн нэгж" ОНӨТҮГ байгуулагджээ.

Төсвийн зардлыг хэмнэх зорилгоор Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр тухайн өдрөөс хойш тендер зарлах болон худалдан авах үйл ажиллагааг зогсоохыг холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасан учир хөтөлбөрт заагдсан газар тариаланд хэрэглэгдэх бага оврын тоног төхөөрөмжүүдийг худалдан авч чадаагүй байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн түнш байгууллага нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийхгүйгээр дүгнэлт гаргасан нь тус газарт тухайн үед ажиллаж байсан удирдлагуудын хариуцлага, санаачилгагүйтэй холбоотой юм.

НҮХААГ уг хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар гаргасан тайландаа тухайн онд хийх хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтийг 75.0 хувиар дүгнэсэн бол нийслэлийн ЗДТГ-ын

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс тайланд үнэлгээ хийсний үндсэнд үйл ажиллагааны үр дүн гараагүй байгаа учир хэрэгжилтийг 11.2 хувиар гэж тогтоосон байна.

Үнэлгээний дээрх зөрүүтэй байдал нь Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ын үнэлгээ хийх аргачлалыг дээрх 2 байгууллага бодит байдалд нийцүүлэн биелэлтийг тооцоогүйгээс шалтгаалсан байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг өнөөдрийн байдлаар тооцоход ногоон тэжээлийг шинэ технологиор тариалж, хоршооны үйлдвэрлэсэн шилдэг бүтээгдэхүүнийг бий болгох, шинэ сортын ногоон тэжээлийг зах зээлд өрсөлдөх чадвартайгаар нийлүүлэх, тэжээлийн чанарыг алдагдуулахгүй савлагаа боодол хэрэглэх, нэг үнээнээс саалийн хугацаанд 2000 литр сүү авах, хоршоодыг байгуулан тэднийг чадваржуулах, загвар аж ахуйн сургалт явуулах, техник дундын төв байгуулах зэрэг ажлууд одоогоор хийгдээгүйг аудитын баг тогтоон, биелэлтийг 57.0 хувьтай гэж үзлээ.

#### **Үр нөлөө:**

Дээд байгууллагаас гаргасан шийдвэрийг холбогдох байгууллагууд хэрэгжүүлэхгүй ажиллах нь ажлын бодит үр дүнд сөргөөр нөлөөлнө.

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэл, явцын тоо хэмжээ, хувийг батлагдсан аргачлалын дагуу тогтоогоогүй нь ажил хугацаандаа гүйцэтгэгдэхгүй байх, санхүүжилт буруу хийгдэх эрсдэлийг бий болгоно.

***Зорилт 3.1.2. Хөтөлбөрийн Ногоон тэжээл үйлдвэрлэлд бэлчээрийн шинэ менежмент, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, Малчид фермерүүдийн хоршоодыг байгаалах, Хөтөлбөр хэрэгжих газарт загвар аж ахуй болон сургалтын төвийг цогцоор байгуулж ажиллуулах, Техник дундын үйлчилгээний төвийг бий болгоход холбогдох байгууллагуудын оролцооны байдалд дүгнэлт өгөх;***

#### **Шалгуур:**

- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг;
- НИТХ-ын баталсан НЗД-ын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Нийслэлийн 2015, 2016 оны эдийн засаг, нийгмийн зорилт;
- НИТХТ-дийн 2015 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр";
- "Эрх шилжүүлэх тухай" НЗД-ын 2015 оны А/631 дүгээр захирамж;

#### **Бодит байдал:**

Хөтөлбөрийн зорилт 1-ийн хүрээнд: Ногоон тэжээл үйлдвэрлэлд бэлчээрийн шинэ менежмент, дэвшилтэд технологи нэвтрүүлэх талаар.

Нийт хашаалсан 150 га талбайн эхний ээлжийн туршилтыг 10 га газарт 2016 оны 07 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд ХХААХҮЯ-наас нийлүүлсэн тэжээлийн олон наст таримлын холимогоор үрлэгээ хийж, тариалалт явуулсан.

Өтөг бууц цацах тоног төхөөрөмжийг 2016 оны 09 дүгээр сарын 28-нд хүлээн авч цаашид хаягдмал хур өтөг, бууц хэрэглэх тооцоог гаргасан байна. /Зураг/



Хөтөлбөрийн зорилт 2-ын хүрээнд: Малчид, фермерүүдийн хоршоодыг байгуулах талаар.

Өрхийн фермер, ААНБ, иргэдийг хоршооны нэгдсэн сургалтад хамруулах судалгаа явагдаж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд малчид, фермерүүдийн хоршоодыг байгуулж хоршооны гишүүдийн өндөр ашиг шимт саалийн 30 үнээ, 30 тугал, өсвөр насны 30 үхрийг шинээр байгуулагдсан цогцолборт оруулах ажил эхлээгүй байна.

Хөтөлбөрийн зорилт 3-ын хүрээнд: Хөтөлбөр хэрэгжих газарт загвар аж ахуй болон сургалтын төвийг цогцоор байгуулж ажиллах талаар.

НЗД-ын "Эрх шилжүүлэх тухай" 2015 оны А/631 дүгээр захирамжаар 90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермийн аж ахуй байгуулах ажлыг НҮХААГ-т хариуцуулсан дагуу тус газрын даргын 2015 оны А/20 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр тендер зарлагдан дүгнэсэн ба ажлын явц 97.0 хувьтайгаар гүйцэтгэгдсэн байна.

Бүгд Найрамдах Турк улсад үйлдвэрлэсэн үнээ саах хөргөлтийн систем бүхий цахилгаан саалтуурыг төслийн нэгж хүлээн авч хөрөнгөнд бүртгэжээ. Мөн 500 мз багтаамжтай шивх хадгалах савыг ашиглалтад өгөхөд бэлэн болгосон байна.

НҮХААГ нь тендерт шалгарсан "Эрчим-Өгий" ХХК-тай агаараар цахилгааны шугам татах ажлыг гүйцэтгүүлсэн боловч газар олгогдоогүй байхад ажлын зураг, төсөв хийж батлуулсан, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдээгүй зэргээс шалтгаалж фермийн

барилгын байрлалыг өөрчилснөөр 520 метр газарт цахилгааны шугамыг нэмж татах болсон байна.

Хөтөлбөрийн зорилт 4-ийн хүрээнд: Техник дундын үйлчилгээний төвийг бий болгох талаар.

НХХААГ-т хариуцуулсан "Техник дундын төв"-ийн барилга баригдсан боловч одоогоор худалдан авсан техникүүдээ тавих зориулалтаар ашиглаж байна.

#### **Шалтгаан:**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр нийслэлийн 2016 оны төсөвт 332.0 сая төгрөг батлагдсан боловч Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр тухайн өдрөөс хойш тендер зарлах, худалдан авалт хийхийг зогсоосноос шалтгаалж газар тариалангийн бага оврын техник, тоног төхөөрөмжийг тухайн жилд худалдан аваагүй нь 2017 онд тариалалт хийхэд зарим хүндрэл учруулах нөхцөлийг бий болгожээ.

Үрэлгээний техник тариалалтын хугацаанаас хоцорч ирсэн тул шинэ дэвшилтэд технологиор зөвхөн 10 га газарт тариалалт хийсэн байна.

Малчид, фермерүүдийг хоршиж тэдгээрийн 90 үхрийг цогцолборт оруулахаар хөтөлбөрт тусгагдсан боловч суурин болон бэлчээрийн аж ахуйг хослон хөгжүүлдэг малчид, фермерүүд сууршлын бүсээсээ шилжиж явах сонирхолгүй нь цогцолборын ажил даруй эхлэх цаг хугацаа үгүй байна.

90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолборын барилга байгууламжийг төслийн нэгж хүлээн аваагүй нь зураг, төсвийг алдаатай хийснээс цахилгааны шугам татах ажил дутуу байгаа, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийхгүйгээр дүгнэлт өгснөөр усны ундрага тооцогдоогүй, хөрсний гадаргуугийн сонголт буруу хийгдсэнтэй холбоотой байна.

#### **Үр нөлөө:**

Тариалалт хугацаандаа хийгдээгүйгээс шалтгаалж тухайн жилд ногоон тэжээл хураан аваагүй байна.

Аудитын баг мэргэжлийн байгууллагаар тооцоолуулснаар 520 метр цахилгааны шугамыг 30.0 сая төгрөгт багтаан хийж болох байхад НҮХААГ 40.0 сая төгрөгөөр хийлгэх тооцоо гаргасан нь төсвийн хөрөнгийг үргүй зарцуулахаар байна.

Цогцолборын ажил эхлэх нөхцөл бүрдээгүй байгаа нь бий болсон хөрөнгө ашиглагдахгүй байх, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах эрсдэл үүснэ.

***Зорилт 3.1.3. Хөтөлбөрийн үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-аас зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүн, тайлагналтад үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгөх;***

#### **Шалгуур:**

- Монгол Улсын Иргэний хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- НИТХТ-дийн 2015 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр";
- НИТХТ-дийн 2015 оны 121 дүгээр тогтоол;
- Нийслэлийн Засаг даргын 2016 оны Б/09, 328, А/493 дугаар захирамжууд;
- Газрын даргын тушаалууд.

### **Бодит байдал:**

НЗД-ын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Б/09 дүгээр захирамжаар "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ын даргаар Хишигбаатарын Алтанхуягийг томилсон ба өөрийн нь хүсэлтийг үндэслэн газрын даргаас чөлөөлж 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/328 дугаар захирамжаар тус газарт менежерээр ажиллаж байсан Гаваандоржийн Галдөлийг НЗД-ын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн саналд үндэслэн тус газрын даргаар дэвшүүлэн томилжээ.

НЗД-ын 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/493 дугаар захирамжаар төслийн нэгжийн бүтцийг баталж, орон тоог 10 албан хаагчтай байхаар тогтоосон байна.

Шинээр томилогдсон газрын дарга байгууллагын дүрмийн заалт, хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ зарим албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг, батлагдсан албан тушаалын нэршлийг өөрчлөх /сургалтын үйл ажиллагааг төсөл санаачилагч гүйцэтгэх болон техник, тоног төхөөрөмж олноор нийлүүлэгдсэн учир сургагч багшийн орон тоон дээр автын инженер- механикч ажиллуулах, 100 га талбайд тариалалт хийгдсэний дараа талбайн манаач, эргүүл ажиллуулах зэрэг/ төсөл боловсруулан НЗД-д хүргүүлжээ.

### Байгууллагын дүрмийн талаар

НИТХТ-дийн 2015 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан 11 бүлэг, 54 заалт бүхий дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж иржээ.

Батлагдсан дүрмээр тус газар нь 6 багц бүхий ажил үйлчилгээ явуулахаас "Олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакуумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх", "Нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх", "Тэжээлийн чанарыг дээшлүүлснээр сүүний гарцыг нэмэгдүүлэх", "Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах" багц ажлууд одоогоор хэрэгжиж эхлээгүй, бэлтгэл хангах үе шатны гүйцэтгэлтэй байна.

### Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын талаар

Газрын даргын 2016 оны А/02 дугаар тушаалаар 11 бүлэг бүхий хөдөлмөрийн дотоод журмыг батлан, хэрэгжүүлэн ажиллажээ. Журмын зарим заалтад өөрчлөлт оруулах шаардлага гарсан болон энэхүү журам нь албан хэрэг хөтлөлтийн зааврын шаардлагыг хангахгүй байсан учир шинээр томилогдсон газрын дарга 2017 оны А/06 дугаар тушаалаар дотоод журмыг шинэчлэн баталж мөрдүүлсэн байна.

Одоогийн мөрдөж байгаа дотоод журмаас ажлаас хожимдсон цагийн нийлбэрээр ажил тасалсанд тооцох; ажлын цагаар, ажлын байран дээр хүүхдээ байлгахгүй байх заалтыг хасах, ар гэрт нь гачигдал гарсан албан хаагчид үзүүлэх тэтгэмжийн хэмжээний зөрүүг арилгах, ажлын 2 хүртэлх өдрийн цалингүй чөлөөг олгох албан тушаалтанг тодорхой болгох зэргийг дахин авч үзэж шаардлагатай бол журамд өөрчлөлт оруулах, өвөө, эмээ, асран хамгаалагч нь нас барсан тохиолдолд тодорхой хэмжээний буцалтгүй тэтгэмж олгох заалтыг нэмэлтээр оруулахыг аудитын багаас байгууллагын менежерт зөвлөсөн болно.

### Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ, контрактын талаар

Газрын даргаар ажиллаж байсан Х.Алтанхуяг нь 2016 онд үр дүнгийн гэрээ болон контракт байгуулан ажиллаагүй. Харин тус газрын төсвийн шууд захирагч Г.Галдөл нь 2017 онд Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчтай Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмын аргачлалын дагуу үр дүнгийн гэрээ /гэрээний хавсралтыг салбар хариуцсан орлогч даргаар батлуулсан/, нийслэлийн Өмчийн харилцааны газартай контрактыг тус тус байгуулан ажиллаж байна.

Төрийн үйлчилгээний албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалт, байгууллагын дотоод журмын дагуу хөдөлмөрийн гэрээг байгуулан /зарим гэрээнд ажилтан

гарын үсэг зураагүй байсан/ ажилласан боловч жилийн эцсээр дүгнэн урамшуулал олгоогүй байна. Харин ажил олгогчоос үйлчилгээний албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг 2017 оноос сар бүр дүгнэдэг болжээ.

Ажлын байрны тодорхойлолт, хүний нөөц, хувийн хэргийн бүрдүүлэлтийн талаар

Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолд үндэслэн боловсруулсан ажлын байрны тодорхойлолтыг нөхөн баталгаажуулалт хийсэн байна. Ажлын байранд тавигдах ерөнхий шаардлагаас үзэхэд цаашид тоног төхөөрөмжийн оператор, автын механикчийн ажлын байранд тухайн мэргэжлийн иргэнийг сонгон шалгаруулж ажиллуулах шаардлагатай.

Газрын хэмжээнд 2016 онд 10 албан хаагч ажиллаж ирснээс 5 албан хаагч хотоос алслагдсан бүс нутагт улирлын байдалтайгаар очиж ажиллах ар гэрийн боломжгүйгээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн учир төдий тооны иргэнийг ажилд туршилтийн хугацаагаар томилсон байна.

Ажилчин, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг нэг бүрчлэн шалгахад нярав, тоног төхөөрөмжийн операторын хувийн хэрэгт байх материал бүрдэл дутуу, менежерээс бусад албан хаагчийн хувийн хэрэгт өмнө ажиллаж байсан байгууллагын ажил байдлын тодорхойлолт байхгүй байна.

Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар

Ажилд орохыг хүссэн иргэн, ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн албан хаагчдаас 14 өргөдөл хүлээн авч тухай бүр, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллажээ. Нийслэлийн иргэд хүлээн авах төвүүдээс тус газарт өргөдөл, гомдол ирээгүй байна.

Газрын хэмжээнд 42 албан бичгийг гадагш явуулснаас байгууллагын цахим сайттай болохыг хүсч нийслэлийн Мэдээллийн технологийн газарт 2 удаа явуулсан албан бичиг өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна. Гаднаас ирсэн 12 албан бичигт хариутай албан бичиг байхгүй байна.

Дотоод хяналтын талаар

Тус газрын үйл ажиллагаа эхлэлийн төдий байсан учир дотоод хяналтын нэгж байгуулах шаардлага өнгөрсөн онд тавигдаагүй байна. Харин байгууллагын хэмжээнд дотоод хяналтын чиглэлээр доорхи хороо, зөвлөл, комиссууд ажиллаж хяналт шалгалт явуулжээ. Үүнд:

- Байгууллагын Ёс зүйн хороог газрын даргын 2016 оны А/12 дугаар тушаалаар менежер Г.Галдөлөөр даргалуулан 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Уг хороо 2016 онд хийх ажлын төлөвлөгөө гарган хурлаараа хэлэлцэн баталсан байна. Төлөвлөгөөний дагуу нийт албан хаагчдад НЗД-ын 2010 оны 686 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг судлуулсан ба "Эерэг зан хандлага, харилцаа" сэдэвт мэдээлэл хийлгэжээ. Тайлант хугацаанд тус хороонд болон нийслэлийн өргөдөл, гомдлын цахим сайтад тухайн байгууллага, албан тушаалтанд хандсан ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээлэл ирээгүй байна.

- Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийг газрын даргын 2016 оны А/07 дугаар тушаалаар менежер Г.Галдөлөөр даргалуулан 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Зөвлөл нь 2016 онд хийх ажлын төлөвлөгөө гарган хурлаараа хэлэлцэн баталсан байна. Төлөвлөгөөний дагуу байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, холбогдох баримт бичгийн бүрдэл, бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтыг шалгаж, хөрөнгийн тооллого явуулж тайлагнасан ба эд хариуцагч нартай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулуулжээ. Зөвлөл нь байгууллагын эд хөрөнгийн ашиглалтыг хангалттай, чанар байдлыг хэвийн гэсэн дүгнэлт гаргасантай тус аудитын багийн дүгнэлт адил байна.

- Байгууллагын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн А.Гэрэлтуяа, агрономич Б.Баярцэцэг нар даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу ажилтнуудын ажлын цаг ашиглалт, байгууллагын санхүүгийн ил тод байдал, архив албан хэрэг хөтлөлт, төслийн үндсэн үйл

ажиллагааны явц, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд шалгалт хийж тайлагнан ажиллажээ.

Албан хаагчдын цагийн бүртгэл тогтмолжоогүй, шилэн дансанд мэдээ тайланг хуулийн хугацаанд байршуулаагүй, зарим мэргэжилтэн, туслах ажилчин удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй гүйцэтгэсэн, албан хэрэг хөтлөлтийн "edoc" програмын ашиглалт хангалтгүй, баримтууд архивлагдаагүй, зарим тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хугацаандаа хийгдээгүйгээс тариалалт хойшлогдож ургац алдсан, барилга байгууламжийг бүртгэлд аваагүй дутагдлууд дээрх хяналт шалгалтаар илэрсэн байна.

#### **Шалтгаан:**

"Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ын даргаар 2016 оны 02 дугаар сард томилогдсон, төсвийн шууд захирагч Х.Алтанхуяг нь төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ, нийслэлийн Өмчийн харилцааны газартай контракт байгуулаагүй, байгууллагын дүрмийн 4 заалтыг хэрэгжүүлээгүй учир НЗД-ын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/327 дугаар захирамжаар ажлаас чөлөөлөгджээ.

Батлагдсан дүрмээр тус газар нь 6 багц бүхий ажил үйлчилгээ явуулахаас 4 багц ажил хэрэгжиж эхлээгүй байгаа нь хөтөлбөрт төлөвлөгдсөн үе шатны хугацаа болоогүй, төсөв батлагдаагүйтэй холбоотой байна.

Байгууллагын дүрэмд Удирдах зөвлөлтэй, бизнес төлөвлөгөөтэй байхаар заасан ч хэрэгжээгүй нь тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаа эхлэлийн төдий байгаагаас шалтгаалжээ.

Тайлант хугацаанд газрын даргын "А, Б" тушаал тус бүр 17-г гаргахдаа Ишийн Дорж гэж бичих атал Иш овогтой Дорж /нэрийг жишээгээр авав/ гэж буруу бичсэн, зөв бичгийн дүрмийн алдаа ихтэй, бичвэрийн хэсгүүд албан хэрэг хөтлөлтийн стандартын бус, газрын даргын тушаалаар байгуулсан комисс, ажлын хэсэгт гадны байгууллагын албан хаагчийг удирдлагатай нь зөвшилцөхгүйгээр томилдог нь тухайн үед энэ ажлыг хариуцаж ажилласан болон тушаалын төсөл боловсруулсан мэргэжилтнүүдийн мэргэшил, ажил хариуцах чадвар сул байснаар илэрхийлэгдэж байна.

Дотоодын хяналт шалгалтаар илэрсэн дутагдлууд нь тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудын ажлын хариуцлага, санаачилга сул, ажил зохион байгуулах мэдлэг, үр чадваргүйтэй холбоотой байна.

***Зорилт 3.1.5. Төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгөх;***

#### **Шалгуур:**

- Төсвийн тухай хууль;
- ТБОНӨ-ийн тухай хууль;
- НББ-ийн тухай хууль;
- НИТХТ-ийн 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн №66 дугаар тогтоол “*Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам*”.

#### **Бодит нөхцөл байдал:**

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагаандаа Санхүүгийн тооцоолох компанийн санхүүгийн тайлангийн “Acoulous”, цалингийн “Payroll” програмуудыг ашиглаж байна.

Тус төслийн нэгж нь 2016 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын хуулийн этгээдээр бүртгүүлж 6046231 тоот регистрийн дугаар, 0000114289 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэйгээр, санхүүгийн ажил гүйлгээг 2016 онд Төрийн сангийн банкны 200051070, нэмэлт санхүүжилтийн 200051469 тоот дансаар явуулж иржээ.

Аудитад хамрагдах хугацааны санхүүгийн баримтанд нэгдүгээр гарын үсгийг дарга Х.Алтанхуяг, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Мөнхдөл нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын төсвийн шууд захирагчид 2016 онд нийслэлийн төсвөөс урсгал зардалд 158,375.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 137,792.0 мянган төгрөгийн урсгал санхүүжилтийн орлого орсноос үйл ажиллагааны зардалд 132,049.3 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 5,742.7 мянган төгрөгийг нийслэлийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 2016 оны үйл ажиллагааны зардал, үр дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Нийт дүн		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	48 992.6	44 648.2	4 308.4	91.2
2	Ажил олгогчоос төлөх ндш	5 388.9	4 915.3	473.6	91.2
3	Гэрэл цахилгаан	2 400.0	747.5	1 652.5	31.1
4	Байрны түрээс	25 453.4	24 503.4	950.0	96.3
5	Тээвэр (шатахуун)	26 408.0	14 550.3	11 857.7	55.1
6	Бичиг хэрэг	1 467.7	1466.9	0.8	99.9
7	Шуудан, холбоо	3 099.3	1 639.5	1 459.8	52.9
8	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3 460.0	3 460.0	0	100
9	Багаж хэрэгсэл	7 868.0	7 868.0	0	100
10	БҮТЭлэгдэх зүйл	2 237.1	2 237.0	0	100
11	Тавилга	19 000.0	19 537.1	-537.1	102.8
12	Урсгал засвар	6 200.0	5 850.0	350.0	94.4
13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 050.0	590.0	460.0	56.2
14	Хичээл үйлдвэрийн дадлага хийх	500.0		500.0	
15	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2 500.0		2 500.0	
16	Даатгалын үйлчилгээ	2 000.0		2 000.0	
17	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100.0		100.0	
18	Тээврийн хэрэгслийн татвар	250.0		250.0	
<b>Нийт дүн</b>		<b>158 375.0</b>	<b>132 049.6</b>	<b>26 325.7</b>	<b>83.4</b>



2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу нийслэлийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тайлант онд “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ыг байгуулж, үйл ажиллагааны зардалд шаардагдах санхүүжилтийг төсвийн тодотголоор батлагдах хүртэл НЗД-ын нөөц хөрөнгөнөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэхээр захирамж гаргаж, төсөв батлагдтал 46,410.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансаараа дамжуулан авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Аудитаар тус төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлан, харилцах дансны баримт, бэлэн мөнгөний кассын баримт, хөрөнгө материалын тайлангууд зэрэг баримт материалууд хамрагдаж, тус байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт, төрийн өмчийн ашиглалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, эд хөрөнгийн тооллого, тооцоо бодолт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, тайлан тэнцлийн гаргалт, байгууллага хоорондын тооцоо, тооллого хийж тооцоо бодолтыг хамруулсан болно.

Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тайлант онд Сангийн сайдын баталсан жишиг НБББББ-ыг үндэслэн өөрсдөө нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2016 оны 01 дүгээр сарын 27-ноос мөрдөн ажилласан байна.

Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг цахим хуудсааролон нийтэд ил тод, нээлттэй, ойлгомжтой мэдээлэх, мэдээлэлд иргэд, олон нийтийн оролцоог хангах зорилгоор байгууллагын шилэн данс шинээр нээж өгөгдсөн маягтын дагуу хугацаанд нь цахимаар мэдээлж ирсэн байна.

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” тухай журмын дагуу “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” нь <http://shilendans.gov.mn/> цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### **Өмнөх шалгалтын талаар**

Нийслэлийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийгдсэн байна. Уг аудитаар төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан бэлтгээгүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, нэмэгдэл цалинг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр олгосон, бараа, материалын тайлангийн үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан, зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, зардлаар тайлагнасан зэрэг материаллаг хэмжээний нийт 51,642.6 мянган төгрөгийн алдаа илэрч “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгсөн байна. Дээрх дүгнэлтийг үндэслэн 51,642.6 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс 46,842.9 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 520.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4,279.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

#### **Хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын талаар:**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,055,364.5 мянган төгрөгийн, байгууллагын төсвөөр 27,405.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

/мянган төгрөг/

Д.д	Данс	Эх үүсвэрүүд		
		УТХО	Байгууллагын төсөв	Нийт
1	Авто тээврийн хэрэгсэл	488 600.0	-	488 600.0
2	Тоног төхөөрөмж	429 000.0	13 895.3	442 895.3
3	Тавилга, эд хогшил	-	12 629.8	12 629.8
4	Бусад үндсэн хөрөнгө	137 764.5	-	137 764.5
5	Бусад биет бус хөрөнгө	-	880.0	880.0
	<b>Дүн</b>	<b>1 055 364.5</b>	<b>27 405.1</b>	<b>1 082 769.6</b>

Тус байгууллага нь 2016 онд НӨХГ-ын 6/2686, 6/4414 , нэгжийн даргын А/06, А/09 тоот тушаалуудаар 31 нэр төрлийн 27,405.1 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,055,364.5 мянган төгрөгийн хөрөнгийг НӨХГ-ын зөвшөөрлийн дагуу данс бүртгэлд тусгасан байна.

### Эргэлтийн хөрөнгө:

/мянган төгрөг/

Бараа материалын нэр	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Тусгай зориулалтын материал	78 000.0	9 380.6	68 619.4
Дуусаагүй үйлдвэрлэл	10 795.2		10 795.2
Бичиг хэргийн материал	1 517.6	1 429.3	88.3
Аж ахуйн материал	2 621.4	1 500.4	1 121.0
Түлш, шатах тослох материал	2 345.0	2 345.0	0
Хангамжийн материал	4 207.5	4 207.5	0
<b>Дүн</b>	<b>99 486.6</b>	<b>18 862.8</b>	<b>80 624.3</b>

Тус нэгж 2016 онд 99,486.6 мянган төгрөгийн материал орлогод авч, 18,862.8 мянган төгрөгийн материал зарцуулсан байна.

### 3.2 ДҮГНЭЛТ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тухайн жилд төлөвлөсөн ажлуудыг НҮХААГ болон "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ханган ажиллажээ. Төслийн нэгж 90 үхрийг хаанаас, хэзээ авах нь тодорхойгүй, цогцолборын үндсэн үйл ажиллагаа явагдаж эхлэх нөхцөл одоогоор хангагдаагүй байна.


### 3.3. ЗӨВЛӨМЖ

- "Бэлчээрийн менежмент төслийн нэгж"-д Нийт хашаалсны 150 га буюу хааш хаашаа 15 км урт талбайд мал оруулахаас хамгаалахын тулд цолцолборын манаачид мотоцикл авч өгөх асуудлыг шийдвэрлэх;

- Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1 дэх, "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай" Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох, 2015 оны 483 дугаар тогтоолын 1.1 болон 2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн газрын даргын шууд удирдлагад ажиллах дотоод хяналтын ажилтанг томилон ажиллуулах, "Дотоод хяналтын журам" гарган мөрдөх;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын байдалд Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын аргачлалын дагуу үнэлгээ өгж байх;
- Тодорхой мэргэжил шаардах ажлын байранд иргэнийг сонгон шалгаруулалтаар томилох;
- Ажилчин, албан хаагчдын хувийн хэргийг бүрдэл болгох;
- Хөтөлбөрт заагдсан байршил болох Улаанбаатар хотоос зүүн хойшоо 45 км дэх "Улиастайн голын эх" байгалын цогцолбор газарт энэ оноос үр, бордооны тариалалтын судалгаа, туршилт явуулах зориулалтаар ашиглах саналыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, шаардлагатай зардлын талаар нийслэлийн төсвийн тодотголд санал өгөх;
- Малчид, фермерүүдэд хэрэгжиж буй хөтөлбөрийн талаарх танилцуулга бэлтгэж тараах, нийслэл дэх өөрийн вэб сайтад сурталчилгааг байршуулах;
- Малчид, фермерүүдийн хоршоо байгуулж 90 үхэр бүхий цогцолборын ажлыг эхлүүлэх;
- Цахилгааны шугам нэмж татах ажлын тендерийг 30.0 сая төгрөгт багтаан зарлаж дүгнэх;
- Нийслэлийн Газрын албанд: СХД-ийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Нарийний хөндийн "Шар хоолойн ам"-нд "Бэлчээрийн менежментийн төслийн нэгж"-ийн ашиглаж буй хашаалсан талбайд суурьшсан 2 иргэнийг нүүлгэн шилжүүлэх;
- Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх "Улиастайн голын эх" байгалын цогцолборт газрын "Бэлчээрийн менежментийн төслийн нэгж"-ийн судалгаа шинжилгээ хийх зориулалтаар ашиглах талбайд дүүргийн Засаг даргын 2014, 2015 онуудад 5 удаагийн захирамжаар 25 иргэнд 1,8 га газар олгосон шийдвэрийг хүчингүй болгуулах;
- Нийслэлийн Байгаль орчны газарт: СХД-ийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Нарийний хөндийн "Шар хоолойн ам"-анд "Бэлчээрийн менежмент төслийн нэгж"-ийн ашиглаж буй хашаалсан 150 га талбайд тэр орчмын иргэд мал оруулдагийг зогсоохын тулд цогцолборын манаачид "Байгаль орчны идэвхтэн байцаагч"-ийн эрх олгох асуудлыг судалж шийдвэрлэх;

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЖАВЗАН

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ  
ОРЛОГЧ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЭНХБАТ

БЭЛТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ЖАМБАЛДОРЖ

ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ АУДИТОР

Д.НАНСАЛМАА

ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Т.АРИУНЦЭЦЭГ